

НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**МАНАЙ СИМПОЗИУМЫН ТАЛААР ЗӨВЛӨЛТИЙН
ХЭВЛЭЛД БИЧСЭН НЬ**

1980 оны зургадугаар сарын 24-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо нэрт монголч эрдэмтэд, хятадыг судлаач, эдийн засагч, түүхч, археологич угсаатны зүйч, гүн ухаантан, хуульч, хэл шинжээчид оролцсон БНМАУ-ын эсрэг хятадын эрх баригчдын их гүрний дээрэнгүй бодлогыг илчлэн шүүмжлэх нь» сэдэвт эрдэм шинжилгээний симпозиумыг Дорнодахины судлалын хүрээлэнгээс зохион явуулсан билээ. Уг симпозиумд оролцсон Зөвлөлтийн эрдэмтэн Р.М.Неронов ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн хэвлэл «Алс Дорнодын асуудал» сэтгүүл (№ 4. 1980)-д бичихдээ симпозиум БНМАУ-ын орчин үеийн нийгэм-эдийн засаг, улс төр, үзэл суртлын асуудлууд, монгол-хятадын харилцааны түүхийн асуудлуудыг өргөн хүрээтэйгээр нарийвчлан үзэж, Хятадын удирдагчдын одоогийн улс төрийн бодлого, түүний цаашдын хандлага чиглэлд марксист-ленинист шинжлэх ухааны дүгнэлт хийсэн байна.

Хятадад сүүлийн үед монголын түүх, түүний дотор хүннү, сяньби, түрэг, уйгур, киданчуудын талаар олон тооны ном зохиол гарсныг илтгэлүүдэд тэмдэглэсэн байна. Саяхан БНМАУ-д «Монголын нууц товчоо» хэмээх түүхийн дурсгалт бичгийг хэвлэн гаргажээ. Хятадын хэвлэлд Чингис хааны талаар түүхэн үүрэг холбогдлыг мушгин гуйвуулсан өгүүлүүд гарч байна. Хятадууд аль хэзээнээс нааш БНМАУ-ын хилийн дагуу археологийн шинжилгээ хийсээр байна. Эдгээр ном зохиол, өгүүллийн гол зорилго нь монголчууд эртнээс нааш хятадын газар нутаг дээр амьдарч, эрт дээр үеэс эхлэн «хятадын олон үндэстний нэгдмэл гэр бүл»-д багтаж байсан, хятадыг монголчууд зээлсэн нь улс орны дотоод хэрэг, хятад бус ард түмэнд өөрийн соёл гэж байгаагүй, зөвхөн хятадын соёлын ачаар соёл иргэншилд хүрсэн гэх мэт зүйлээ «шинжлэх ухааны» үүднээс батлахад чиглэжээ. Шинжлэх ухааны нэр зүүсэн энэ мэт эрэл хайгуул нь түүхэн баримттай харшилд-гийг хуралд оролцогчид яруу тод илтгэн харуулав гэжээ.

БНМАУ ЗХУ-ын эрдэмтэд түүхийн маоист гуйвуулалтыг илчлэх талаар их ажил хийлээ. Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан экспедиц монголчуудын эртний соёлын судлалд хувь нэмэр оруулж байгаа бөгөөд тэд судалгаа шинжилгээгээрээ маоист түүхчдийн шинжлэх ухааны эсрэг баримтлалыг уудлан илрүүлэхэд тус дөхөм үзүүлж байна. «БНМАУ-ын түүх» (гуравдугаар хэвлэл), «Төв Азийн нүүдэлчин ард түмнүүдийн соёл иргэншил», «Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх» (1917-1977) зэрэг бас бус хамтын бүтээлүүд маоист түүх завхруулагчдыг илчлэн шүүмжилсэн олон тооны баримт сэлт багтаажээ.

Симпозиумд оролцогчид нэн шинэхэн түүхийн болон олон улсын харилцааны зарим асуудал, тэдгээр нь орчин үетэй хэрхэн холбогдохыг нарийвчлан үзсэн юм. Тухайлбал Мао Зэдун болон ХКН-ын үндсэрхэг үзэлт бусад удирдагчид БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай асуудалд сөрөг байр суурь баримталж байгааг заасан байна. гэж Р.М.Неронов тэмдэглэжээ.

ХКН-ын удирдлага дахь Маогийн бүлгийнхэн бүр хоёр орны төрийн харилцаа өрнөн хөгжиж байсан 1949-1960 оны үед ч БНМАУ-ыг өөртөө нэгтгэх тухай асуудлыг монголын ард түмэн, түүний засгийн газрын ар хударгаар нэг биш удаа тавьж байсан юм.

Хятадын удирдагчид 1960-1970-аад онд засгийн газар хоорондын хэлэлцээрээр өөртөө ноогдсон үүргийг биелүүлээгүйгээр барахгүй, монгол хятадын хилийн тухай гэрээг НҮБ-д одоо болтол бүртгүүлэхгүй байна. (Зөвхөн БНМАУ-ын засгийн газар л гэрээг бүртгүүлсэн юм.)

Өнөө үед Бээжин БНМАУ-ын эсрэг чиглэсэн суртал ухуулга, улс төрийн болон судалгааны ажлыг хүчтэй болгож, Зөвлөлтийн эсрэг үзлийг өөгшүүлэн, социализмын орнуудын эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлж байна гээд Р.М.Неронов манай эрдэмтдийн илтгэл мэдээлэлд орчин үеийн Бээжингийн нийгэм-эдийн засгийн болон үндэстний бодлого, археологийн баримт мэдээнд гүн гүнзгий шинжилгээ хийсэн тухай дурджээ.

Симпозиум дээр БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч Б.Ширэндэвийн хэлсэн үгийн талаар Р.М.Неронов бичихдээ илтгэгч: «Орчин үед Бээжин, БНМАУ-ын олон улсын нэр хүндийг доромжлох оролдлогоо үргэлжлүүлж, капитализмыг алгасан социализмд хүрсэн монголын ард түмний түүхэн туршлагыг хөгжиж байгаа орнуудын нүдний өмнө гутаахыг оролдсоор байгаа юм гэж онцлон тэмдэглэв. Хятадад Монголын түүхийг бүдүүлгээр гүйвуулж байна. Энэ ажиллагаагаа одоо нарийвчлан сайтар боловсруулсан төлөвлөгөөтэйгээр эрдэм шинжилгээний хэдэн зуун ажилтан, монголыг судлаач, хятадыг судлаачдын хүчээр гүйцэтгэж байгаа юм. Бээжин Төв Азийн соёл иргэншлийн судлал болон дэлхийн монголын судлалын төвд удирдах байр суурь эзлэхийг эрмэлзэж байна» гэж цохон тэмдэглэв гэжээ.